

## УЛС ОРНУУДЫН ЯЗГУУР СОЁЛЫН БАРИЛДЛАГА

*Б.Цэцэнцолмон\**

Оюун ухаант хүн үүсэн буй болж, бүрэлдэн тогтсон цагаасаа эхлээд нээн илрүүлж, нэхэн ухаарсан зүйл нь тоолж гүйцэшгүй их, тоймлож баршгүй арвин билээ. Түүхэн урт хугацааны явцад оршин суусан газар орон, эрхэлсэн аж ахуй, ахуй амьдралын хэв маяг, аливаад хандах үзэл сэтгэлгээнээсээ хамаараад дэлхий нийтийн улс түмэн засаг захиргаа, нийгмийн байгуулал, соёлынхоо хүрээгээр өвөр хоорондоо ялгарч ирсэн. Хэдий тийм боловч тэдний дунд сэтгэхүйн нийтлэг төстэй зүйл бас ч үгүй үлдсэн байх юм. Үүний нэг нь гэвэл байгалийн аливаа үзэгдэл юмс цаанаа ямар нэг далдын хүчтэй байдаг гэсэн эртний хүмүүсийн сүсэг бишрэлээс эхтэй, бидний оршин буй энэ ертөнцөөс гадна хий ухаар биетэн суудаг өөр нэг ертөнц байдаг гэж үздэг итгэл үнэмшил юм. Энэ үзэл нь байгальтай нарийн шүтэлцээтэй үүссэн хүн төрөлхтний шашны анхны хэлбэр бөө мөргөлтэй холбоотой юм.

Монгол орны хувьд бөө судлал XIX зууны сүүл үеэс эхэлсэн<sup>1</sup> гэж үздэг бөгөөд үүнээс хойш олон эрдэмтэн зан үйл, ёс заншил, яруу найраг, аман зохиолынх нь талаас судалгаа хийсээр өнөө хэрд улам нарийсан хөгжсөөр байгаа билээ. Монгол бөөгийн зан үйлд дуудлага, тамлагаа аялгуулан дууддаг нэгэн ёс байгаа нь чухал судлагдахуун мөн болох нь гарцаагүй. Энэ үзэгдэл өөр олон орны бөөгийн болон бус шашинтай улс түмэнд оршсоор ирсэн нь мөнөөх дээдсийн сүнс онгод оршдог өөр нэгэн ертөнцтэй харилцах арга замыг олох гэсэн хүн төрөлхтний нийтлэг сэтгэлгээний илрэл юм.

Тухайлбал эртний Энэтхэгийн нүүдэлчин ард түмний бүтээсэн Ведийн утга зохиол дөрвөн зүйлийн “Самхида” буюу цоморлигоос бүтдэг бөгөөд хамгийн эртнийх нь “Ригвэда” гэдэг дууллын Ведэд 1028 дуулал, түүний дараахи “Самвэда” гэдэг дууллын Ведэд 1549 дуулал багтаж<sup>2</sup> байсан нь Вед шүтлэгийн тэнгэр нэрийн дуудлага ажээ. Энэ нь дээд шүтээн, тэнгэр онгодтойгоо дуу аялгууны зүйлээр харилцаж, түүнээ урьж залан уяраан хайлах зорилго бүхий бөөгийн зан үйлтэй утга санаа адил ажээ. Бөөгийн энэ дуудлагын ая аялгуу бол зөвхөн урлаг уран сайхны зориулалттай зүйл төдий бус ахуй амьдралтай нь нягт уялдаатай оршдог нийгмийн харилцаан дахь онцгой зүйл юм.

\*Б.Цэцэнцолмон - СУИС-ийн багш, магистрант

Малайзын овог аймгийн хөгжим нь ч энэ мэт ач тустай зүйл ажээ. Хот газрын хүмүүс нь сэтгэл зүйчидэд хандахаас илүүтээ тосгоны чадалтай “боомор” (“bomor”-малайзын бөөгийн нэр)-ын сэтгэл зүйн эмчилгээг даган бишрэх болсон байна. Энд ая хөгжимгүй бөөг чадалгүйд тооцож, нутгийн иргэд уг хөгжим аялгуунд нь хөгжин цэнгэхийн зэрэгцээ ямар нэгэн ид шидийн гэмээр эрч хүчийг олж авдаг хэмээн үздэг ажээ. Одоо ч “путри боомор” (“putri bomor”-анагаах увидастай арга засалч бөөгийн нэр) нар ховсдох урлагаараа өвчтнийг анагаан илааршуулдаг хэвээр байна.<sup>3</sup>

Энэ мэт эртний уламжлалт бөө мөргөлтэй улс түмний дунд биет хүн орших энэ ертөнц болон хий дүртэн орших нөгөө ертөнц, нартын орон болон харанхуйн орны хооронд харилцаа холбоо тогтоон хэлмэрчилж байдаг хэн нэгэн хүн (үүнийг газар бүрийн өөр өөрийн хэлээр нэрийддэг), түүний ярьж харилцаж байдаг ямар нэг хэл байдаг гэсэн сэтгэлгээний нийтлэг зүйл ажиглагдаж байна. Үүний өөр нэг жишээ гэвэл Солонгосын ард түмний дунд хэдийгээр загалмайтны шашин өргөн дэлгэрсэн боловч язгуурын бөөгийн шашныхаа уламжлалыг хадгалан үлдсэн нь ч цөөнгүй ажээ. Орчин үеийн Сөүл хотыг иргэд эдийн болон оюун санааны хэрэгцээгээр бөөгийн зан үйлд (mudang) оролцох нь олонтаа. Сүсэгтэн олныг бишрүүлэн хүсэл зоригий нь гүйцэлдүүлдэг бөө хүн үгийн болон аялгууны шидээр тэнгэр онгодтой харьцаж, зарим тохиолдолд зан үйлд оролцогсдын өөд болсон эцэг эхийн сүнс бөөд орж тэднийг хооронд нь уулзуулдаг байна.<sup>4</sup> Үүнээс гадна монгол бөөгийн тахилгад онгод шүтээндээ хонины бүхэл мах, сүү цагаан идээ, цай, архи өргөдөг бол солонгос бөө гурил нарийн боов, жимс шүүсээр тахилга өргөдөг байна.<sup>5</sup>

Дээд шүтээн тэнгэр онгодлоо идээ ундааныхаа дээжийг өргөж, тогтсон нэгэн сайн өдөр ёслол үйлдэн дуу дуулснаар өвөг дээдэстэй уулзан учирсан мэт болдог бас нэгэн зан үйл бөөгөөс өөр шашинтны дунд ч байдаг ажээ. Тухайлбал Югославын өмнөд хязгаарт орших Македоны Бүгд Найрамдах Улсын Роса тосгоны бүсгүйчүүл өөд болсон өвөг дээдэсдээ зориулан “Тага” хэмээх гашуудлын дуу дуулан тэдэнтэйгээ уулзсан мэт болж сэтгэл санаа нь тайвширдаг байна. Тэдний үзлээр энэ бол уран сайхны утга агуулгатай ердийн дуу биш харин өөд бологсад руу нь хөтлөх зам болж өгдөг.<sup>6</sup> Энэ дууны аялгууг Росанчууд аль нэг ардын дуунаас авах бөгөөд “Тага”-гаа эртний дууны нэгэн төрөл гэж үздэг байна.

Монгол бөөгийн дуудлагыг ч мөн ардын дууны аялгуунд үндэслэн зохиох агаад дэргэдэх хүмүүсээс илүүтэй дээд тэнгэр онгодыг урьж залан уриалан дуудах зорилготой тул бөөгийн дуудлагын ая аялгуу нь монгол ардын хөгжмийн “Уриа дуудлагын ая аялгуу” гэсэн төрөл айд хамаардаг гэж үздэг.

Тэнгэр сахиус, урьдас дээдсээ шүтэн тахих, сүнс онгодыг нь дуудан харилцах эдгээр зан үйлд ажиглагдах язгуур сэтгэлгээний нийтлэг төстэй зүйлийг цаашид хэл шинжлэл, хөгжим судлал, хүн судлал, угсаатны зүй зэрэг салбар ухааны үүднээс харьцуулан жишсэн цогц судалгаа хийх нь хүн төрөлхтний орчлон ертөнц, юмс үзэгдлийн тухай үзэл санаа хэрхэн бүрэлдэн тогтож, өргөжин тэлснийг тодруулан тогтооход хэрэг тустай болох юм.

### ИШЛЭЛ ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Буриадын эрдэмтэн Б.Доржийн “Харын шашин-Монголын бөөгийн мөргөл” (1846) бүтээлийг энэ талын анхны дорвитой бүтээлд тооцдог.
2. Ж.Бадраа “Монгол, Энэтхэгийн хөгжмийн барилдлага”. “Үнэн” сонин. №56(17273) 1989.3.7.
3. William P.Malm “Music in Malaysia”. “The World of Music”. /Intercultural Music Studies/ Berlin.3/ 1979
4. Antonetta L.Bruno “The Gate of Words: Language in the Rituals of Korean Shamans”. International Institute for Asian Studies. November 2002.
5. Purev.O. “Some Similar Characteristics in View and Rituals of Mongolism and Korean Shamanism”. Korea and Mongolia Toward common Prosperity in the 21st Century. Nov.1998
6. Nahoma Sachs “The Facts of Death: An Antropologist views Musical Symbolism”. “The World of Music”. /Intercultural Music Studies/ Berlin.3/1979